




Бүх хүнд хүртээмжтэй  
дэвшингүй хөгжил



## ЖАЙКА-ИЙН СУРГАЛТЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА




# Жайка-ийн сургалтын хамтын ажиллагаа

Жайка-ийн хэрэгжүүлдэг Японы техникийн хамтын ажиллагааны нэг хэлбэр болох “сургалтын хамтын ажиллагаа” нь 1954 онд Япон улс “Коломбын төлөвлөгөө” олон улсын байгууллагад элсэн орсоноорхөгжлийн албан ёсны тусламж болон Японд анх хэрэгжиж эхэлсэн. Тэр үеэс хойш өнөөг хүртэл Япон дахь сургалтанд 280000 гаруй хүмүүс оролцоод байна (2011 оны бодит тоо). Тус хамтын ажиллагаа нь хөгжиж буй орнуудын эх орныхоо хөгжлийг авч явах хүмүүсийг Японд хүлээн авч, төрийн удирдлага, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, болосрол, эрүүл мэнд, зам тээвэр, харилцаа холбоо зэрэг олон салбарын хүний нөөцийн хөгжилд дэмжлэг үзлүүлэх, тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх зорилготойгоор сургалтын хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг ба Япон улсын хөгжиж буй орнуудад хэрэгжүүлж буй “хүн” –ээр дамждаг техникийн хамтын ажиллагааны хамгийн анхан шатны хэлбэрийн нэг юм.

## Сургалтын хэлбэрүүд, сургалтын тосургалтанд оролцогчийн тоо

### (2011 он Жайка-ийн сургалт хариуцсан алба )



\* Урт хугацааны сургалт нь 2010 оноос хойш шинээр элсэлт авахаа болжсон.

## Монгол дахь сургалтын хамтын ажиллагаа

Монголоос олон төрийн албан хаагч Япон дахь сургалтанд оролцсон ба 1977 оноос хойших оролцогчдын тоо нийтдээ 3000 орчим болоод байна. Эдгээр сургалт төгсөгчид нь Монголын хөгжлийг авч явах боловсон хүчнийхээ хувьд нийгмийн бүхий л салбарт хувь нэмрээ оруулж байдаг. Төгсөгчдийн ихэнх нь суралцсан мэдлэг, туршлагаа түгээхийн тулд мөн өөрсдийн ажиллаж буй байгууллагынхаа асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн сургалтаар олж авсан туршлагадаа үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөө (action plan)-г боловсруулдаг. Жайка нь сургалтын дараах хамтын ажиллагаа (Follow up)-ны хүрээнд хэд хэдэн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлсэн ба сургалт төгсөгчдийн холбооны туслалцаатайгаар мөн төгсөгчид семинар зохион байгуулан, сургалтанд оролцож чадаагүй мэргэжил нэгтгүүд, нэг байгууллагын хамт олон болон орон нутгийнханд зориулан сургалтаар олж авсан мэдлэг, туршлагаа хуваалцах замаар сургалтын үеэр боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр хүчин чармайлт гаргадаг. Ингэж хүчин чармайлт гаргасны үр дүнд Жайка-ийн төсөлд санал боловсруулан оруулж, тэр нь батлагдан хэрэгжиж буй ба монгол хэл дээр төрөл бүрийн гарын авлага гарган, семинар зохион байгуулж холбогдох хүмүүст тараах зэргээр буцаж ирсний дараа амжилттай ажиллаж буй олон жишээ бий. Дараагийн хуудаснаас иймэрхүү амжилт гаргаж буй төгсөгчдийн талаар танилцуулна.

### Монголын сургалтын хамтын ажиллагаанд оролцогчдын тоо

Урт хугацааны сургалт	Сэдэвчилсэн сургалт		Тухайн оронд зориулсан сургалт	Залуучуудын сургалт	Нийт
	Групп	Бүс нутгийн			
2007ЯСЖ хүртэл	13	833	55	758	138
2008ЯСЖ	5	44	16	67	30
2009ЯСЖ	2	63	17	71	30
2010ЯСЖ	1	61	13	113	29
2011ЯСЖ	0	65	10	151	28
2012ЯСЖ	0	54	10	135	26
合計	21	1,120	121	1295	281
					2,838

ЯСЖ-Японы санхүүгийн жил, тухайн оны 4 сарын 1-ээс дараа оны 3 сарын 31 хүртэл

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 1

### МӨНХЖАРГАЛЫН ТОДБИЛЭГ

Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Геологийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн

2009 он Байгаль орчинд ээлтэй үр ашигтай

уул уурхайн хөгжил, ашиглалт сургалт



#### Сургалт төгсөгч болон оролцсон сургалтын талаар

2009 он 9 сараас 2009 он 12 сар хүртэл Акита мужийн Косака хотхон дахь “MINETEC” буюу Уул уурхайн технологийн олон улсын институттэд хэрэгжсэн “Байгаль орчинд ээлтэй үр ашигтай уул уурхай ба металл ашигт малтмалыг дахин боловсруулах нь” сургалтанд оролцсон.

#### Сургалтын сайн нөлөө

**Хувь хүний түвшинд:** Японы уул уурхайн бохирдлын түүх болон хууль эрхзүйн тогтолцоо, үр ашигтай уул уурхайн технологийн хөгжил, байгаль орчинд ээлтэй уул уурхайн опборлолтын аргачлалын талаар мэдлэг эзэмшсэн. Эдийн засаг, нийгмийн яягаатай байдлаас болоод Японд суралцсан зүйлээ бүгдийг нь Монголд хэрэгжүүлэх боломжгүй боловч, Монголын уул уурхайн салбарын хөгжил шинэчлэлд хэрэг болохоор зүйлүүдийг сонгон, тайлан бичин яамандаа өгсөн.

Тэрбээр Монголын Геологийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн ба тус холбооноос зохион байгуулсан салбарын хуралд Жайка-гийн сургалтын талаарх өөрийн туршлагаар илтгэл таввсан. Уг холбооны шугамаар Японы уурхайтай очиж танилцах аялал зохион байгуулах зэргээр ажлын бус чиглэлээр мөн мэдлэгээ хуваалцаж байна.

**Байгууллагын түвшинд:** Сургалтаар Монголын геологи, уул уурхайн салбарыг хөгжүүлэхдэх хүний нөөцийг хөгжүүлэх нь чухал юм гэдгийг ойлгон, энэ салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл боловсруулан яаманд өгсөн. Яам үүнийг дэмжин, Сангийн яамаар дамжин Жайка-гийн техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжихээр батлагдсан.

**Тогтолцоо, хөгжлийн асуудлын түвшинд:** Одоогийн байдлаар нүдэнд харагдахуйц үр дунд хүрээгүй байгаа ч Монголд ашигт малтмалын хайгуул, уул уурхай хөгжлийн зэрэгцээ байгаль орчинд хор хөнөөлгүй технологи нэвтрүүлэхээр зорьж байгаа тул хэрэв Жайка-гийн техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжквэл уул уурхайн салбарын хөгжлийн тогтолцоо болон түүнд тулгарч буй асуудлын шийдвэрлэхд томоохон хувь нэмэр болно гэж үзэж байна. Улмаар төслөөр дамжуулан, Монгол мэргэжилтнүүд Япон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломжтой болох ба Япон хүний ажилсаг, тууштай зан чанарт Монголчууд суралцууштай.

**Бусад:** Карьеерт нөлөөлсөн тухайд буцаж ирээд сургалтын агуулга, өнөөг хүртэлх ажлын туршлага дээр үндэслэн эрдэм шинжилгээний ажил бичсан. Мөн өнгөрсөн жил Монголын Шинжлэх ухаан технологийн их сургуульд геологи - эрдэс судлалын доктор (PhD)-ын зэрэг хамгаалсан. Япон дахь лекц, танилцах аялалаар японы аж үйлдвэрийн салбарын хөгжлийн үндэс нь уул уурхай байсан. Монгол ч ирээдүйд эдийн засгийн хөгжлийн төлөө энэ салбарыг чухалчлах шаардлагатай гэдгийг маш сайн ойлгосон. Үүнийг ойлгосноор өөрийн ажлын хичнээн чухал гэдгийг хамасралж, ажилдаа хандах хандлага сайжирсан.

#### Шууд бус нөлөө

Сургалтанд Японы соёлтой танилцах үйл ажиллагаа багтаж, Япон хүмүүстэй харилцсанаар Япон илүү ойр дотно санагдах болсон. Японы эдийн засгийн хөгжлийг түшиж тулж ирсэн нь өндөр боловсрол, соёлтой боловсон хүчин юм гэдгийг мэдэрч ойлгон, Монголд ч мөн хүний нөөцийг хөгжүүлэх нь чухал юм гэдгийг ойлгосон.

Жайка-гийн сургалт төгсөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа боловч ажил ихтэй учраас идэвхтэй оролцож чадахгүй байгаа. Сургалтын үеэр тус Уул уурхайн технологийн олон улсын институттэд Монголоос сургалтанд хамрагдсан 20 хүн байдгийг мэдсэн. Эх орондоо буцаж ирээд өдгээр хүмүүстэй боломжийн хэрээр холбоо тогтоон, өнгөрсөн жилээс энэ чиглэлийн төгсөгчдийн уулзалт, клуб бас байгуулахаар ярилцаж байгаа.

#### Сургалтын сайн нөлөө гарсан шалтгаан

**Сургалтын агуулгын тухайд:** Лекц сонссоны дараа уурхай дээр очиж байдалтай нь танилцуулж байсан нь шинэ мэдлэгийг өөрийн болгоход дөхөм болж байсан. Улмаар Монголын тухай тайлан тавих үеэр Японы уул уурхайн салбарын компани болон их сургуулийн багш нар зэрэг өргөн хүрээний хүмүүс оролцон, оролцогч тус бүрийн яриаг анхааралтай сонсох байсан. Иймэрхүү Япон хүмүүстэй харилцаж байсан нь идэвх санаачлагaa нэмэгдүүлэхэд тус нэмэр болсон.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 2

### ДЭГДЭВИЙН ПХАМААСҮРЭН (зүүн)

Ус сувгийн удирдах газрын санхүүгийн хэлтсийн эдийн засагч.

2004 он Оршин суугчдад сурталчлан таниулах хөтөлбөр.

Зургийн баруун талд ДОРЖХОРОЛЫН ТУЯА

Мөн Жайка-ийн сургалт төгсөгч



2004 оны 12 сараас 2005 оны 1 сар хүртэл Токио хотын ус сувгийн газар, Ёкохама хотын ус сувгийн газар, ЭНЖИЭС ХК зэрэг газруудад хэрэгжсэн оршин суугчдад сурталчилан танилуулнах хөтөлбөрт оролцсон. Тухайн үед УСУГ-ын санхүүгийн хэлтсийн дарга, одоо энэ хэлтэсдээ эдийн засагчаар ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Лекц, мэтгэлцээн, танилцах аялал зэргийг хослуулсан сургалтын хөтөлбөр, цагийн хувиарлалт зэрэг нь маш их санаа ёгсэн ба одоо өөрийн ажил дээрээс сургат явулахдаа ашиглаж байна. Мөн УСУГ болон орон нутгийн ус сувгийн ажилтнууд нь орон нутгийн оршин суугчдыг хүндэт зочин мэт хүндэлж байсан байдлыг хараад өөрөө ус сувгийн ажилтны хувьд оршин суугчидтай аль болох сайхан харилцаатай байхыг хичээж ажиллаж байна. Мөн сургалтанд оролцсоноор явалж жирийн ард иргэд ус хэмнэх хэрэгтэйг ойлгох бол гэж үргэлж дотроо бодож явдаг болсон. Монголчууд цэвэр усиг үйлдвэрлэх боловсруулж буй дамжлагыг мэддэггүй, крантаа нээхэд ус гардаг гэдгийг л мэдэх хэмжээний учраас усaa хэмнэе гэдэг ухамсар багатай байдал. Япончууд болон Монголчуудын ухамсын ялгааг биеэр мэдэрсэн нь буцаж ирсний дараах үйл ажиллагаанд түлхэц болж ёгсэн.

**Байгууллага, тогтолцооны түвшинд:** Ус сувгийн удирдах газрын гол үйл ажиллагааны хүрээнд хүүхдүүдэд чиглэгдсэн сурталчилгааны үйл ажиллагааг санаачлан, энэ санаачлага маань байгууллагын жилийн төлөвлөгөөнд орон, өнөөг хүртэл тасралтгүй хэрэгжих ирлээ. Ёкохамагийн ус сувгийн музейтэй танилцсан нь тулхэц болсон. Айлуудад ус хүрэх хүртэл ямар олон байгууламж, дамжлагыг дамждаагүй нүдээр харсан. Мөн энэ дамжлагыг жирийн ард иргэдэд дэлгэж таниулан усaa хэмнэе гэдэг ухамсар дээшлэхэд үнэхээрийн ашигтай юм гэдгийг ойлгосон. Буцаж ирсний дараах гол үйл ажиллагаанууд нь

1. 2005 онд Монголын алдартай зохиолчоор усны тухай жүжгийн зохиол бичүүлэн, жүжгийг тавихад Улаанбаатар хотын 60000 гаруй бага сургуулийн сургачид ирж узсэн.
2. 2009 онд УСУГ-ын сургалт, мэдээллийн төвийн барилга баригдахад гар бие оролцсон.
3. Нийслэлийн боловсролын хорооны дэмжлэгтэйгээр хотын бүх дунд сургуулиудын дунд усиг хэмнэх сэдэвтэй эсслийн уралдааныг зохион байгуулсан.
4. 2009 онд Монголын дизайнертэй хамтран, усны зөв хэрэглээний сэдэвтэй цуврал комик ном бүтээсэн. УСУГ-т ирсэн хүүхдүүдэд тарааж байгаа.
5. Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран, усны сэдэвтэй зурагтай сургачийн дэвтэрийг хийн, тараасан.
6. 2011 онд усиг хэмнэх сэдэвтэй телевизийн шторк хийлгэсэн. УСУГ-т Японы буцалтгүй тусламжаар ус түгээх байгууламжийг шинэчлэх тесэл хэрэгжих байсан. Шууд хамтран ажиллагч байгаагаар ч ус сувгийн удирдах газрын удирдлагын хувьд мэдээлэл ирдэг байсан. Тэр үеэс Япон хүний ажилдаа хандах хандлага, ялангуяа цагийг ягштал баримтлалдаг байдал, урьдчилан маш нарийн төлөвлөдөг гайхамшигтай хүмүүс гэдгийг анх мэдсэн. Сургалтанд оролцсоноор хэзээ хэзээнээс илүү Япончуудын ажиллах арга барилыг гайхамшигтайг биеэр мэдэрсэн.



### Сургалтын агуулгын тухайд:

1. Лекц болон танилцах аялалаар арвин хөтөлбөр
2. Сургалтын төгсгөлд үйл ажиллагааны төлөвлөгөө бичин, эх орондоо буцсаны дараа хийх ёстой зүйлийг нарийн төлөвсөнийг хэлж болно. Ялангуяа танилцах аялал нь жирийн ард иргэдэд ус сувгийн үйл ажиллагааг ойлгуулах үйл ажиллагааг эхлүүлэхэд тодорхой санаа ёгсэн үр ашигтай зүйл болсон.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ З

### УРАНЦОГИЙН ЛХАМСҮРЭН

Ус сувгийн удирдах газрын хэрэглэгчийн үйлчилгээний хэлтсийн дарга. 2010 он Ус сувгийн байгууламж



2010 оны 5 сараас 7 сарын хооронд цэвэр усны байгууламжийн технологийн сургалтанд оролцсон. Тухайн үед техникийн хэлтсийн инженер байсан бол буцаж ирээд 2011 оны 2 сараас УСУГ-ын хамгийн том хэлтсийн дарга болон тушаал дэвшсэн.

**Хувь хүний түвшинд:** Японы усны алдагдлын хайгуулийн технологи болон төхөөрөмжийн хэрэгцээ, усны хоолойн суурьлуулалт, засварын тэмдэглэлийн чухалыг гүнзгий ойлгосон. Мөн сургалтаар Японы сүүлийн үеийн технологийг нүдээр үзэн, өөрөө инженер хүнийхээ хувьд үргэлж шинэ мэдлэг, технологитой танилцан, Монголын ус сувгийн хөгжилд илүү хувь нэмрээ оруулах юмсан гэж хүчтэй бодох болсон.

**Байгууллага, тогтолцооны түвшинд:** Сургалтаар суралцсан цэвэр усны технологийн дотроос ялангуяа УСУГ-ын ажлыг сайжруулахад ашигтай гэж үзсэн технологи, аргачлалыг нэвтрүүлж ажиллаж байна. Жишээ нь ус тасарах хугацааг маш бага байлгах хоолойн засварын технологийг нэвтрүүлэхээр санаачлаглаа гаргасан. Мөн Японы усны алдагдал хайгуулын технологи, төхөөрөмжийг худалдан авахаар хэлэлцэж байна. Японд усны алдагдлыг хайгуул хийн, үр ашигтүү ус урсахыг багасган, хоолойг ойр ойрхон засварлан хайр гамтай урт хугацаагаар ашиглах арга хэмжээ хэрэгжиж байсан. Монголд мөн усны алдагдлыг хайгуул хийх боловч давтамж нь арай цөөн байна. Япон улс шиг усны алдагдлын хайгуулын технологийг өргөн нэвтрүүлэх шаардлагатай юм байна гэдгийг ойлгож, буцаж ирснийхээ дараа энэ технологи, төхөөрөмжийг танилцуулах танилцуулгыг ажилтнуудтайгаа хамтран хийсэн. Улмаар усны хоолойн мэдээлэлийн санг (хоолой, траншейны сүлжээний зураг, засвар үйлчилгээний тэмдэглэл, засварын компани зэрэг) бүрдүүлэх нь чухал учраас 2012 он жилийн төлөвлөгөөнд тусгуулсан. Улмаар усан сангийн нуурын эргэн тойронг ногоожуулах нь сургалтаар олж авсан санааны нэг юм. Японы ус сувгийн газруудтай танилцах үед ус цэвэршүүлэх байгууламж зэрэг байгууламжийн эргэн тойронд мод, цэцэг тарин, цэцэрлэгт хүрээлэн мэт зохион байгуулсан нь хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. Монголд эсрэгээрээ ус сувгийн байгууламж эзгүй газраас ялгаагүй тул заавал дуураймаар үйл ажиллагааны нэг байсан юм. Албан тушаал ахих тухайд сургалтын агуулга одоогийн албан тушаалтай нийцэж байгаа бөгөөд сүүлийн үеийн технологи, бусад орууудын ус сувгийн талаарх мэдлэгтэй болсон нь ажлаа сайжруулахад сайнаар нөлөөлж байгаа, дээр нь инженер байснаа УСУГ-ын хамгийн том хэлтсийн дарга болон дэвшсэн нь Японд сургалтанд оролцсон нь үнэлэгдсэн байх гэж хувьдаа бодож явдаг.

#### Сургалтын үр нөлөө гарсан шалтгаан:

**Сургалтын агуулгын тухайд:** Лекц, практик, танилцах аялал зэргийг маш сайн хослуулж чадсан нь сургалтанд оролцогчдын ойлголтыг гүнзгийруулэхэд сайнаар нөлөөлсөн. Ялангуяа Японы ус сувгийн байгууламжтай очиж танилцсан нь ус сувгийн байгууламжийг ногоонжуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэргээр тодорхой арга хэмжээтэй холбогдож ирсэн. Мөн сургалтын агуулга, ажлын агуулга яг нийцэж байх нь сургалтын агуулгыг ажил хэрэг болгоход чухал юм.

**Сургалтанд оролцогчийн чадварын тухайд:** Буцаж ирээд харьялагдах байгууллагын удирдах албан тушаалд очсон нь сургалтаар олж авсан мэдлэг, техникийг хувь хүний түвшингээр тогтохгүй, байгууллага, тогтолцооны түвшинд нэвтрүүлж чадсан шалтгаан гэж үзэж байна.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 4

### ЖАМБАЛДОРЖИЙН МЯНДАС

Монгол улсын байгалийн түүхийн музейн  
Маркетингийн менежер буюу дэд захирал  
2010 он Музей судлал



#### Сургалт төгсөгч болон оролцсон сургалтын талаар

2010 оны 4 сараас 7 сар хүртэл Японы үндэсний музей дээр голчлон хэрэгжсан "Музей судлал" сургалтандаа оролцсон. 2002 оноос одоог хүртэл Маркетингийн менежер буюу дэд захирлаа ажиллаж байна.

#### Сургалтын сайн нөлөө:

**Хувь хүний түвшинд:** Музейн менежментэд шаардлагатай музей судлалын ерөнхий онол дээр үзмэр цуглуулах болон хадгалах аргачлал, үзмэрийн фото зураг авах аргачлал зэрэг ажилтай маань шууд холбогдох технологоос суралцсан. Эзэмшсэн мэдлэгээс ялангуяа монголын музейнуудад хэрэгтэй гэж үзсэн үйл ажиллагаа нь ① Хүүхдүүдийн дунд музейд боловсролын ажил зохион байгуулах ② Орон нутгийн оршин суугчидтай хамтран үзмэрийн хайгуул хийн музейн сан хөмрөгийг баяжуулах ажил /Орон нутгийн иргэдтэй хамтарсан үйл ажиллагаа/ ③ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үзмэрийн дэглэлтийн байдал ④ Музейгээр хүмүүжлийн болон боловсрол олгох үйл ажиллагаа явуулах зэрэг нь хэрэгцээтэй байсан учир эдгээр зүйлийг илүү түлхүү суралцаан эх орондоо эргэж ирэн хэрэгжүүлж болохуйд тодорхой санаануудз олж авч чадсан.

Эх орондоо эргэж ирээд хамт төгссөн нөхдийн хамт сургалт семинар зохион байгуулах үедээ Япон дахь сургалтаар ашиглаадж байсан зарим нэг зөвшөөрөгдсөн сургалтын материалыаас орчуулан мөн тэндээс олж авсан мэдлэгээ баяжуулаан Монголын нөхцөл тохируулан ашигласан. Сургалтаар дамжуулан зөвхөн яриад байх биш бодитоор үзэж харж, суралцаахын чухалыг биенээр мэдрэх ойлгосон тул сургалт явуулах үедээ Японы музейнүүдийн үйл ажиллагаатай танилцах үедээ авч байсан фото зураг, болон бусад гарын авлагууд, танилцуулга, музейн билет зэргийг сургалтандаа ашиглан лекцээ явуулж байна.

**Байгууллагын түвшинд:** Музей судлалын талаар суралцах боломж хомс байдаг орон нутгийн музейн ажилтнуудад зориулан Япон дахь сургалтынхаа агуулгыг танилцуулах зорилгоор воркшоп, семинар зохион байгуулах төсөл боловсруулан удирдлагадаа танилцуулалт зөвшөөрөгдсөн. Сургалтын талаар орон нутгийн музейн ажилтнуудад танилцуулан цахим хэлбэрээр түгэсэн.

**Хөгжлийн асуудлын түвшинд:** Сургалтын дээд зорилт болоо "Соёл, аялал жуулчлалын хөгжил болон боловсрол, судалгааны байгууллагынх нь хувьд музейг сайжруулах" –д хувь нэмэрээ оруулж байна. Тухайлбал Жайка-ийн сургалт төгсөгч мэргэжил нэгтгүүдийн хамтаар улсын чанартай 36 музейд зориулан Японд эзэмшсэн мэдлэг туршлагаа тайлагнах, танилцуулах воркшопыг 11 сараас хэрэгжүүлэн өнөөг хүртэл 4 удаа 140 музейн ажилтан оролцоод байна.

Анхны воркшопын заах хичээлийн хөтөлбөрүүдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд түүн дотроо тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд болон харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан үзүүлэгийн дэглэлтийн талаар сургалт явуулан, тэргэнцэрэй иргэдийн холбооныдартыг урьж оролцуулж байсан. Ийм арга хэмжээ Монголд анх удаа болсон. 2 дахь удаагийн орон нутгийн воркшопоор төвийн бүсийн аймгийн музейнүүдэд, 3 дахь удаагийнх нь Хархоринд, 4 дэх удаагийнх нь баруун бүсийн аймгийн музейн ажилтнуудад зориулан зохион байгуулсан. Хархорины музейд өмнө нь Өвөрхангай аймагт зохион байгуулсан сургалтын үр дун болох хүүхдүүдэд зориулсан боловсролын ажлыг түршиж, хэрэгжүүлж эхэлсэн мэдээ хулээж аваад баяртай байгаа. Төдийлэн хотод болж буй бусад сургалтандаа оролцох боломжкор хомс байдаг хөдөө орон нутгийн музейн ажилтнуудад тухайн орон нутгат нь очиж сургалтаа зохион байгуулж, Японд сурсан мэдлэгээ түгээх гол зорилго байлаа.

#### Шууд бүс үр нөлөө:

Япон оронд сурсан мэдлэгээ хот, хөдөөгийн музейн ажилтнуудад түгээн дэлгэрүүлэх гол арга зам нь сургалт зохион байгуулах явдал байсан. Үүгээр бид олон музей хамруулж чадсан болон музейн ажилтнуудын үр чадвар, мэдлэгийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой болсон юм.

#### Сургалтын үр нөлөө гарсан шалтгаан:

**Сургалтын агуулгын тухайд:** Олон болон практик, танилцах аялалыг хослуулсан, улмаар музейн ажилтан, их сургуулийн профессор багш, судлаачид зэрэг олон терпийн багш нарын баг олон өнцгөөс мэдлэг, технологийг эзэмшилжүүлэхийн тулд ажиллаж байсан.

**Сургалтын дараах дэмжлэгийн тухайд:** Воркшоп зохион байгуулах хөрөнгийн тухайд 2,4 дэх удаагийнхад Жайка-гаас дэмжлэг аван хэрэгжүүлсэн. Бусад үед тухайн зохион байгуулж байгаа орон нутгийн музейнүүдээс ихээхэн дэмжлэг авсан. Воркшоп зохион байгуулах, төсөл боловсруулахад адил сургалтандаа оролцсон Жайка-гийн сургалт 2010 оны төгсөгч А. Янжив, 2011 оны төгсөгч Г. Ялалт нарын туршлага бас их дэмжлэг болсон. Нөгөө талаас музейн үзвэрийг сайжруулах, ялангуяа харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан тогтор цэгэн бичлэгээр үзвэрийн тайлбар бичих, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам хийх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг анхаарсан байгууламжийн тухайд хөрөнгө мөнгө шаардлагатай тул бид шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх тал дээр ярилцаж байна

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 5

### ТҮНДЭВИЙН ОДГЭРЭЛ

Халдварт өвчин судлалын үндэсний хүрээлэнгийн Эмгэг

судлалын лабораторийн эрхлэгч

2006 он Клиникийн шинжилгээний технологи II



2006 оны 12 сарыас 2007 оны 2 сар хүртэл Японы Жүнтэндогийн их сургуульд хэрэгжсэн клиникийн шинжилгээний технологийн сургалтанд хамрагдсан. Тухайн үед ХӨСҮТ-ийн эс судлалын шинжилгээний лаборантаар одоо бол ХӨСҮТ-ийн эмгэг судлалын лаборантырын эрхлэгчээр ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Сургалтаар эзэмшсэн зүйлээ олон хүмүүст хүргэмээр байна гэж төгсгэчдийн холбоо Жайка-ийн сургалтын дараах дэмжлэг (Follow up)-ийн талаар мэдээлэл өгсөн. Тус дэмжлэгийг аван 2010 онд Нийслэлийн лаборантуудад зориулан нэг өдрийн семинар зохион байгуулан 25 хүн оролцсон. Япон дахь сургалтаар суралцсан воркшоп хэлбэрээс санаа авч үзээс өмнө Япон дахь сургалтаар олж авсан мэдлэг, туршлагаа тайлагнан, үзээс хойш хэлэлцүүлэг хэлбэрээр хэрэгжүүлсэн. Мөн Япон судлаачидтай хамтран ажиллах байхад Япон хүмүүсийн ажилсаг, асуудлыг өөрөө шийдвэрлээ гэдг чин сэтгэл, хүчин чармайлттай байдлаас суралцсан билээ. Мөн судлаач хүний хувьд ярианы хэлбэр, бусдыг хүндлэх, ойлгохын чухалыг суралцсан. Би өөрөө ч доод ажилчид болон хамтран ажиллагчтайгаа ижил хэмжээнд харьцаан, мөн Япон хүний ажиллах агаа бариллас зааж сургахыг хичээж явдаг.

Сургалтын агуулгад тулгуурлан дараах байдлаар төвийн халдварт өвчин судлалын оношилгоог сайжруулах тал дээр ажиллаж ирсэн.

**1. Төвийн оношилгооны аргачлалыг түвшинг дээшлүүлэх:** Сургалтаар эзэмшсэн гол эсүүдийн тогтмол шинжилгээний арга зэрэг илүү хурдтай, баталгаа өндөртэй оношилгоо хийх боломжтой технологийг нэвтрүүлсэн. Мөн сургалтаар сурсан шинжилгээний өрөөнүүдийн био аюулгүй байдал болон урьдчилан сэргийлэх стандарт аргачлалтуухайд ч шууд хэрэгжүүлэн лабораторийнхоо өрөөнүүдийн дотоод зохион байгуулалтыг өөрчилсэн. Семинар сургалтын өрөө, хувцас солих өрөө, тур амрах өрөө зэргийг шинээр бий болгосон. Мөн лаборатороос тусдаа байшинд улсын эсийн хадгаламж байгуулсан. Энэ нь Монголдоо анхны арга хэмжээ болсон. Хөгжлийн асуудлын түвшинд

Монголын клиникийн шинжилгээний технологийг сайжруулахад хувь нэмэрээ оруулсан. Тодорхой үр дүнгийн тухайд шинээр байгуулсан туршилтын өрөө болон нэвтрүүлсэн шинэ технологийнхоо ачаар Монголын эх нялхасын үндэсний төв дээр хүүхдийн уушигны үрэвсэлт халдварт өвчиний вирусыг тогтоон, халдвараас урьдчилан сэргийлж чадсан.

Мөн Монголын БЗХӨ-ий оношилгоо бас сайжирсан. Жилд 2 удаа орон даяар 5 газарт очин эсийн лаборатороор чанарын хяналтыг хийж байгаа.

**2. Шинжилгээний багаж төхөөрөмжийн худалдан авалт:** Эсийн шинжилгээний хурд, баталгаатай байдлыг дээшлүүлэхийн тулд Монголоос шинэ төхөөрөмж болох автомат эсийн шинжилгээний төхөөрөмж болон Гламын эсийг будагч бодисоор автоматаар ялгах төхөөрөмж зэргийг худалдан авсан. Худалдан аваадаа Монгол улсын засгийн газар, Глобал сан, ДЭМБ зэрэгээ төсөв мөнгөний тусламж авсан.

**3. Туршилтын өрөө, хадгаламж бий болгох:** Глобал сан болон ДЭМБ-гаас төсвийн дэмжлэг аван, молекулын биологийн туршилтын өрөөг байгуулсан. Албан тушаал ахижад нөлөөлсэн нөлөөлийн тухайд сургалтын агуулгад тулгуурлан БЗХӨ-г оношлох болон мэдрэмжийн шинжилгээг сайжруулахыг судалгааны сэдэвээр сонгон, 2009 оноос Монгол их сургуулийн докторын зэрэг хамгаалахаар сурч байна. Сургалтын үеэр мэргэжлийн мэдлэгээс гадна япон соёл, япон хүмүүсийн ухамсараас суралцаж чадсан ба японд хандах хандлага маань илүү ойр дотно болсон. Ийм боломж олгож өгсөн Японы засгийн газарт чин сэтгэлээсээ баярлалаа. Төгсгэгчдийн холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, Жайка-ийн сургалт төгсгэгчдийн холбоотой харилцаагаа үргэлжлүүлж явна.

**Сургалтанд оролцогчийн онцлогийн талаар:** Эзэмшсэн мэдлэг, технologoo Монголд түгээн дэлгэрүүлэх эрмэлзэл байсан буцаж ирсний дараа байгууллагын удирдлагад тушаал дэвшсэн тул сургалтын агуулгыг ажил хэрэг болгоход эргэн тойроосоо дэмжлэг аваад хялбар албан тушаалд байсан.

**Сургалтын агуулгын тухайд:** Өөрийн мэргэжлийн салбар, сургалтын агуулга, ажлын агуулга яг нийцэж байсан тул сургалтын агуулгыг сайтар эзэмшиж чадсан ба буцаж ирээд түүнийгээ ажил хэрэг болгож чадсан. Мэргэжлийн мэдлэгийг бүрэн ойлгохын тулд сургалтын хугацаа 3 сар орчим байсан нь тохиромжтой байсан. Ажлын төлөвлөгөө боловсруулсан нь буцаж ирээд үйл ажиллагаагаа тодорхой хэрэгжүүлэхэд сайнаар нөлөөлсэн.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 6

### ДОРЖЖАНЦАНГИЙН НЯМСҮРЭН

Клиникийн 2 эмнэлэгийн сувилахуйн тасгийн дарга  
2010 он Сувилахуйн удирдлагын сургалт



2010 оны 9 сараас 12 сар хүртэл сувилахуйн удирдлага сургалтанд оролцсон. Клиникийн нэгдсэн II эмнэлгийн сувилахуйн албаны даргаар ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Сургалтын агуулга, лекц, танилцах аялал, бусад сургалтанд оролцогчидтой санал солилцох зэрэгт миний хувьд бүхий л зүйл анхных байсан. Ялангуяа workshop зохион байгуулах (хэд хэдээрээ групп болон мэтгэлцэн хийж, үр дунгээрээ илтгэл тавих), хичээлийн агуулга тус бүрээр агуултыг нь мартахгүйн тулд тайлан бичдэг нь шилдэг сургалтын арга байна гэж үзсэн учраас ажилдаа нэвтрүүлж байгаа.

**Байгууллага, тогтолцооны хэмжээнд:** Японы эрүүл мэндийн систем болон шинэ сувилагчид зориулсан боловсролын тогтолцоог өөрийн эмнэлэгт нэвтрүүлэхээр ажиллаж байна. Монголын эмнэлгүүдэд шинэ боловсон хүчинд чиглэгдсэн хичээлийн хөтөлбөр байхгүй тул шинэ сувилагч болон ахмад сувилагч адилхан сургалтанд суух болдог эцсийн дундээ шинэ сувилагчийн дутуу дулимаг ур чадвар асуудал болж буцаж ирсний дараа хийсан хамгийн эхний алхам бол нэг сар ээлжийн амралтаа аван сургалтаар олж авсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан “Шинэ сувилагч” гарын авлагыа бэлтгэн, 300 хувийг өөрийн зардлаар хэвлүүлсэн. Энэ нь одоо албан ёсоор Клиникийн нэгдсэн II эмнэлгийн шинэ сувилагч нарт зориулсан сургалтын материал болон ашиглагдаж байна.

**Хөгжлийн бодлогын түвшинд:** Шинэ сувилагч нарт зориулсан гарын авлагын тухайд аль хэдий нь харьялгадах эмнэлэгт маань ашиглагдаж байгаа бөгөөд танилцуулах семинар зохион байгуулах зэргээр нийт орон даяар нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ нь ажил хэрэг боловол Монгол улсын сувилахуйн боловсрол, цаашлаад сувилахуйн технологид дэвшил болно гэж найдаж байна.

Миний ажлын карьеерын тухайд сургалт төгсөөд өнөөг хүртэлх ажлын туршлага, сургалтын агуулгад тулгуурлан сувилахуйн менежментийн сэдвээр докторын дисертация бичиж байна. Монголтой ялгаатай нь Японы сувилагч нар өвчтөнтэй их ойр байдаг нь хүчтэй сэргээдэл төрүүлсэн. Эмч өвчинээс эмчлэн, сувилагч өвчтнээ сувилах үүрэгтэй тул сувилагчийн хувьд өвчтөнтэй харилцах харилцаа маш чухал юм.

Миний хувьд Японы сувилахуй бол дэлхийд топ зэрэглэлдээ орно гэж боддог. Эдгээр агуулгыг өөрийн номондоо багтааж өгсөн тул Япон ёс суртахуун Монгол сувилагч нарын дунд нэвтрээсэй гэж хүсэж байна. Мөн зүн Японы их газар хөдлөлтийн үед сургалт хэрэгжүүлсэн Олон улсын сувилагч нарын холбоонд эмгэнэл явуулах зэргээр Японтой харилцах харилцаагаа нандигнан хадгалж үргэлжлүүлэхийг хүсдэг.



**Сургалтанд оролцогчийн тухайд:** Сувилагчаар ажиллаж эхэлсэн тэр үеэс Монголын сувилахуйн салбарыг сайжруулахад хувь нэмрээ оруулахы чин сэтгэлэсээ зорьж ирсэн. Улмаар би мастерийн зэргийг Монголдоо анх удаа хамгаалаан, докторантад элсэн суралцааж байгаа анхны сувилахуйн мэргэжилтэн билээ. Сувилахуйн мэргэжлийн ажлын 29 жилийн туршлага, мэргэжлийн мэдлэгийн сурьтай байсан маань сургалтын агуулгад суралцах болон буцаж ирээд сурсан мэдсэнээ ажил хэрэг болгоход тус дөхөм болсон гэж бодож байна.

**Сургалтын агуулгын тухайд:** 2011 оны 11 сард Жайка-гийн Монгол дахь төлөөлөгчийн газарт Жайкагийн ажилтнууд, бусад орны сургалтанд оролцогчид, Японы судлаач, багш нарын оролцсон видео конференц болсон. Миний явуулж буй үйл ажиллагааг их сайшааж байсан нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бас нэгэн түлхэц болж өгсөн.

**Буцаж ирсний дараах дэмжих тогтолцооны тухайд:** Холбоонд гишүүнээр элсэн Жайка-ийн сургалтын дараах дэмжлэг (Follow up cooperation)-ийн талаар мэдэж, хүсэлтээ гаргасан.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 7

### ХҮҮХЭНБААТАРЫН ГАНЗОРИГ

Мал эмнэлэгийн хүрээлэнгийн захирал  
(2008 он, Хүнсний аюулгүй байдал)



2008 оны 9 сар-2010 он 9 сар хуртэлх 2 жилийн турш урт хугацааны сургалтанд оролцон, Обихирогийн их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Судалгааны сэдэв маань цагаан идээний найрлагад дун шинжилгээ хийн, хүний биед нөлөөлөх нөлөөллийг судлах байсан. Ялангуяа Монголын хойд талын байгалийн эрс тэrs ур амьсгалтай бус нутагт амьдардаг ард иргэдийн иддэг тэмээний сүүний найрлагыг судлах болон түүний тэжээллэг байдлын тухай судалгаа явуулан, магистарын судалгааны ажил бичсэн. Тухайн үед хүнсний аюулгүй байдлын хүрээлэнгийн ажилтан байсан. Буцаж ирээд 2010 оны 12 сараас одоогийн хүрээлэнгийн захираалаар томилогдон ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Сүүлийн үед Япон дахь судалгааны ажлын туршлагадаа тулгуурлан Монголын хойд талаар нутагладаг хандгайн сүүний найрлагыг судлахаар Монголын мал эмнэлэгийн судлаачидтай ярилцаж байна. Мөн Обихиро их сургуулийн удирдаж байсан багш маань Монголд судалгаа хийхээр ярилцаж байгаа биелэгдэвэл өнөөг хуртэлх судалгааныхаа үр дүнг улам гүнзгийрүүлэх боломжтой болно.

Урт хугацаагаар Япон хүнтэй харилцах боломжтой байснаар Япон судлаачдын хичээнгүй, нухацтай байдал, судалгаандаа бахархалтай хандаж байгаа нь хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. Мөн судалгааныхаа тухай зөвхөн эрдэм шинжилгээний хурал бус интернет, сэтгүүл, танилцуулга зэрэг янз бурийн аргаар жирийн ард иргэдэд өргөн хүрээтэй мэдээлэл хүргэж байсан нь гайхамшигтай санагдсан. Монголын судлаачид судалгааны ажилаа олон нийтэд танилцуулах хичээл зүтгэл дутдаг ба тийм боломж ч хомс байдаг. Жайка-ийн сургалт нь судлаач хүний ухамсарт минь ихээхэн өөрчлөлт авчирсан.

**Байгууллагын түвшинд:** Буцаж ирээд ажлаа сольсон тул одоогийн ажил дээрээ сургалтын агуулгыг шууд тусгах боломж байхгүй. Судалгааны хүрээлэнгийн захиралын хувьд хүрээлэнгийн судалгааны ажилтнуудыгаа өөртэйгээ адиллаар гадаад оронд мэргэжил дээшлүүлэх боломжыг олж аван, юмыг шинэ өнцгөөс хардаг болон, түүнийгээ Монгол дахь судалгааны ажилдаа тусгаж ажиллахыг хүсж явдаг. Тийм орчинг бүрдүүлэхээр хичээж ажиллаж байна. Албан тушаал ахих тухайд одоогийн хүрээлэнд над шиг гадаадад магистарын зэрэг хамгаалсан хүн өөр байхгүй учраас захиралд дэвшсэн.

Буцаж ирсний дараа иймэрхүү хэлбэрээр сургалтын агуулгыг яж хэрэгжүүлж ашиглаж байна вэ гэдгийг ярих тийм боломж байгаагүй. Иймэрхүү судалгаа нь сургалтын агуулгыг дахин сэргээн санаж, улмаар үр ашигтай ашиглах сэдэл өгөхөд холбогдох боломжтой. Цаашид мөн иймэрхүү байдлаар ажиллахыг хүсэж байгаа бусад сургалт төгсгөгчид ямар үйл ажиллагаа явуулж байгаа тухай мэдээлэл өгөхийг хүсэж байна.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 8

### ЗЭСБАЛЖИРЫН АРИУНАА

*Нийслэлийн гаалийн газрын аюулгүй байдал,  
гаалийн үнэлгээний HS (бүтээгдэхүүний  
нэршил болон төрлийг нэгтгэх систем ) кодын  
хэлтсийн дарга  
2008 он Азийн экспортын хяналтын  
технологийг сайжруулах*



2008 он 11 сард 10 хоног азийн экспорт хяналтын технологийн талаарх сургалтанд оролцсон. Тухайн үед Нийслэлийн гаалийн газрын гаалийн байцаагч байсан ба буцаж ирээд шинээр байгууллагдсан хэлтсийн даргаараа томилогдон ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Экспортын хяналт шалгалтанд шаардлагатай хуулийн тогтолцоо, материал бүрдүүлэлт болон хориглосон бүтээгдэхүүний төрөл, зүйлийн жишээ, олон улсын экспортын хяналтын тогтолцооны товч агуулга зэрэгт суралцан, өөрийн мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлж чадсан. Буцаж ирээд сургалтын агуулгыг хуваалцах зорилгоор бүх байцаагчдад илтгэл тавьсан. Илтгэл тавьсан материалдаа сургалтаар тарааж өгсөн сургалтын материал танилцах аялал хийсэн газруудын зургийг ашигласан.

**Байгууллага, тогтолцооны түвшинд:** Сургалтын үеэр олж авсан “Экспорт, импортын үед ялангуяа гаалийн хяналт шалгалаа шаардлагатай химийн бодисын жагсаалт”-ыг Монгол хэл рүү хөрвүүлэн, бүх байцаагчид үзэх боломжтойгоор нь гаалийн ерөнхий газрын дундын серверт хадгалсан. Өнөөг хүртэл төстэй жагсаалт бол байсан боловч хүний биед хортой бодис, цөмийн зэвсэг болон биологийн зэвсгийн найрлагын хувьд яаж ашиглагддаг зэрэг тайлбар бол байдаггүй байсан. Гаалийн байцаагчийн хувьд экспорт, импортын журмаар хориглогдсон бүтээгдэхүүн гэдгийг мэддэг байхаас гадна тэр нь яаж буруугаар ашиглагдаж боломжтой тухай мэдлэгтэй байх нь маш чухал юм. Би өөрөө гаалийн байцаагчаар ажиллаж байсан хүний хувьд байцаагчдад мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх ямар чухал болохыг ойлгож байсан тул сургалтын агуулга, материалд тулгуурлан бүх байцаагчдад зориулан 2 удаа семинар зохион байгуулсан. Цаашлаад 2009 онд байгууллагын жилийн тайландаа семинарын агуулгыг оруулан, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна. Богино хугацааны сургалт байсан бөгөөд Японы соёл, нийгэмтэй танилцах цаг байхгүй байсан тул Япон илүү дотно санаадах зэрэг өөрчлөлт бол нэг их байгаагүй.

**Сургалтанд оролцгчийн онцлогийн талаар:** Буцаж ирээд өөр газарт ажиллах болсон боловч хэлтсийн даргын албан тушаалд очсон тул сургалтаар олж авсан санаагаа байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусгуулах зэрэг сургалтын агуулгыг нэвтрүүлэхэд бол хялбар байсан.

**Сургалтын агуулгын тухайд:** Ажлын агуулга болон сургалтын агуулга нийцэж байсан. Лекц, танилцах аялалыг сайн холбож өгч, хөтөлбөрийн дагуу цагтаа хэрэгжиж байсан тул богино хугацаанд их зүйлийг суралцаж чадсан. Ялангуяа химийн бүтээгдэхүүн, автомашины сэлбэгийн үйлдвэртэй танилцсан нь үйлдвэрийн дамжлаг дахь бүтээгдэхүүнийг мэдэж авахад чухал ач холбогдолтой байсан. Монголд үйлдвэр цөөн байдаг тул экспортлож, импортлож буй сэлбэг яаж ашиглагдаж байгааг нүдээрээ харах боломж олддоггүй.

10 хоногийн богино сургалт байсан ч ажилаа сайжруулахад хэрэгтэй олон зүйлсийг суралцаж чадсан боловч нөгөө талаар Японы соёл, нийгмийн талаар танилцаж чадаагүй нь харамсалтай байсан.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 9

### ТӨМӨРБААТАРЫН ЭРДЭНЭЖАРГАЛ

Хүнс, ХАА, Хөнгөн үйлдвэрийн яамны гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

2009 он 3 сар ХАА-н нэвтрүүлэх тогтолцоог сайжруулах



2006 оноос 2009 хүртэл хэрэгжүүлсэн Жайка-ийн техникийн хамтын ажиллагааны төслөөр “ХАА газар тариалангийн хосолсон загвар аж ахуйг бүрдүүлэх төсөл”-ийн менежерээр ажиллаж байсан ба 2009 оны 3 сард төслийн хамтран ажиллагчийн сургалтанд хамрагдсан.

Хувь хүний түвшинд Японы ХАА-н хоршоологчдын үйл ажиллагааны тогтолцоо, хосолсон аж ахуй, ХАА-н бүтээгдэхүүний тээвэрлэлтийн тогтолцоо зэрэг Японы ХАА-н нэвтрүүлэх тогтолцооны талаар байдал дээр нь очиж танилцан ойлголтоо улам илүү гүнзгийрүүлсэн. Техникийн хамтын ажиллагааны төслийн зорилго нь ХХААХҮ-ийн яам болон ХАА-н нэвтрүүлэх төв зэрэг төрийн байгууллага малчин, тариаланчдад үйлчилгээ үзүүлэн, хосолсон аж ахуй эрхлэх дэмжлэг үзүүлэх ба Японд сургалтанд суун байдалтай танилцсанаар төсөл дууссаны дараа Монголын засгийн газар ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ гэдэг талаасаа суралцсан сургалт болсон.

Мөн Японд Монголоос ялгаатай нь газар тариалан эрхлэгч хамгийн үндсэн түвшний хэрэгцээ бодлого, тогтолцоонд тусгадаг системийг бүрдүүлж чадсан нь хүчтэй сэтгэгдэл төрүүлж байсан. Би өөрөө төрийн албан хаагчийн хувьд газар тариалан эрхлэгчдийн дуу хоолойг сонсдог байдлаар ажиллас хүсэл төрсөн. Жайка техникийн хамтын ажиллагааны төслийн хамтран ажиллагчийн хувьд ажилч хичээнгүй соёлч боловсон Япон хүмүүстэй хамтарч ажиллас боломжтой болсоноор Япон хүнд дуртай болсон Японд очиж үзсэнээр Монголтой харьцуулахад хамаагүй хөгжсөн ХАА-н нэвтрүүлэх систем болон Японы соёл заншилтай танилцан, улам илүү хайртай болсон.

Мөн техникийн хамтын ажиллагааны төслийн агуулгыг улам илүү ойлгож ирсэн. Хамтран ажиллагчийн сургалтанд намайг оролцуулаад бүгд газрын даргаас дээш түвшингийн хүмүүс оролцсон ба төсөл дууссаны дараа үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэх хүмүүс Японд очин техникийн хамтын ажиллагааны төслийн агуулга болон ач холбогдлыг илүү ойлгож авсан нь төслийн тогтвортой хэрэгжилтэнд сайн нөлөө үзүүлсэн гэж үзэж байна.

Сургалтаар танилцах аялал болон практик зэрэг нудээр харж биеэр мэдрэх хөтөлбөрүүд багтаж байсан ба Японы ХАА болон нэвтрүүлэх системийг ойлгуулах талаас хичээж ажилласан байсан.

Хамтран ажиллагч болон өөрийн ажилтангуудаас сүүлийн уед Жайка-ийн сургалтын хугацаа бодиносон соёл заншилтай танилцах хөтөлбөр бараг байхаа больсон гэж сонссон. Тэгэхээр Японд очсон ч Японы өвөрмөц байдалтай танилцах чадахгүй буцаж ирдэг Япон дахь сургалт хүмүүсийг япон оронд элэгтэй болоход нөлөөлж чадахгүй байгаа нь харамсалтай юм. Миний хувьд Японы соёл болон эдийн засгийн хөгжлийг мэдрэх завшаан тохиосон нь мэдлэг, туршлага эзэмшихтэй адил томоохон өгөөжтэй зүйл байсан учраас цаашид иймэрхүү боломжийг жаахан ч гэсэн олгож байгаасай гэж хүсэж байна. Нөгөө талаас сүүлийн жилүүдэд яамны ажилтнууд Койка-ийн сургалтанд их оролцох болсон ба Жайка-ийн сургалттай харьцуулахад соёлын харилцаа илүү багтсан байдаг гэж сонссон.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 10

### ИШЖАМЦЫН ДОНДОГ

*Дорноговь аймгийн засаг даргын тамгын газрын  
мал аж ахуйн хяналтын хэлтсийн дарга  
2004 он МАА/Газар тариалангийн тухай  
өрөнхий ойлголт*



2004 он МАА-н үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрэлийн өрөнхий ойлголтын тухай сургалтанд оролцсон. Тухайн үед Дорноговь аймгийн сумын засаг даргын тамгын газрын ХАА үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа бодлогын газрын ажилтан байсан бол одоо Дорноговь аймгийн МАА-н үйлдвэрлэлийн хяналт шалгалтын хэлтсийн даргаар ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Японд жишээлбэл малын халдварт өвчнийг комьюньютерээр оношлон эмийн жор олгох зэргээр ХАА-н суулийн үеийн технологийн мэдлэгийг эзэмшиж боловч Монголын технологийн түвшин, байгалийн нөхцөл байдал ихээхэн өөр учраас тэдгээр агуулгыг ажил дээрээ нэвтрүүлэхэд хүндрэлтэй байсан.

Япончууд найрсаг, ажилсаг, соёлтой ард түмэн юм. Япончуудтай харилцах боломж олдсоноор Япон орон илүү ойр дотно санагдах болсон.

**ЖАЙКА-тай хамтарч ажиллах тухайд:** Сургалтанд оролцож байх үед олон малчид зуднаар хамаг малаа алдсан байсан ба тэдгээр малчдад тусламжийн арга хэмжээ авах хэрэгтэй байгааг мэдэрч байсан. Сургалтанд оролцохос өмнө буюу 2004 оны үед ЖАЙКА-ийн тусламжтайгаар 600 тооны мал худалдан авч, эмзэг бүлгийн малчдад туслах зорилготой малын сангийн үйл ажиллагаага явуулах боломжтой болсон ба 2011 оны байдлаар 98 айл өрхөд 4279 тооны мал нийлүүлээд байна. Дорноговь аймагт энэ үйл ажиллагаа өндрөөр үнэлэгдэн, малын сангийн тухай хууль гаргахаар болж, одоо хуулийн төсөл дээр ажиллаж байна.

**Сургалтанд оролцгчийн онцлогийн талаар:** Тухайн үед амьдарч байсан Эрдэнэ суманд их хэмжээний зуд болсоны улмаас малын тоо 87,000-аас 50,000 болтлоо буурсан байдалтай ба ядуурал нүүрлэсэн малчдын төлөө ямар нэг юм хийхгүй болохгүй боллоо гэсэн аюултай байдлыг мэдэрч байсан маань төсөл хэрэгжүүлэх хөшүүрэг болж өгсөн. Ийм үед ЖАЙКА-аас дэмжлэг авч чадсанаар төсөл маань ажил хэрэг болж хэрэгжиж эхэлсэн.

## МОНГОЛЫН СУРГАЛТАНД ОРОЛЦОГЧ 11

### ГОМБОЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ

*Булган аймгийн даргын тамгын газрын хүнс, ХАА,  
ЖДҮ-ийн хэлтсийн ажилтан  
2008 он ХАА-н нэвтрүүлэх төлөвлөгөөний  
удирдлага*



2006 он болон 2008 онд ХАА нэвтрүүлэх системийн тухай сургалтанд оролцож байсан. Тухайд үед Булган аймгийн ХАА-н нэвтрүүлэх төвийн нэвтрүүлэх менежер, одоо бол Булган аймгийн засаг даргын тамгын газрын хүнс, ХАА, ЖДҮ-ийн хэлтэст ажиллаж байна.

**Хувь хүний түвшинд:** Японы ХАА-н нэвтрүүлэх систем нь Монголтой ялгаатай нь төрийн төв байгууллага болон орон нутгийн байгууллага аль аль нь ХАА-н нэвтрүүлэхэд дэмжиж байдаг ба газар тариалан эрхлэгчдэд үзүүлэх төрийн үйлчилгээний бүтэцтэй, бүх орон нутгийг хамарч байдгийг мэдсэн. Монголд ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээ бүрэн тогтоогоогүй. Энэ нь улсын хэмжээний бодлого дутагдалтай байдаг ба Япон шиг ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээ хэрэгжихэд саад болж шалтгаан юм байна гэдгийг ойлгосон. Сургалтын туршид боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тулгуурлан, газар тариалан эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт хэрэгжүүлэх, ХАА-н технологийг нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулсан.

**Байгууллага, тогтолцоо, хөгжлийн асуудлын түвшинд:** Буцаж ирээд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тулгуурлан Булган аймгийн Агропарк (ХАА-н нэвтрүүлэх төв шиг байгууламж)-ийг байгуулан, аймгийн 16 суманд зөвлөгөө өгөх үйлчилгээний төлөвлөгөө бичин, хөрөнгө оруулагч хайж байсан. Яг энэ үед IFAD нь улс даяар ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж байсан ба газар тариалан эрхлэгчдэд газар тариалангийн технологи нэвтрүүлэх болон бичил зээлийн үйл ажиллагааг мөн явуулж байсан. IFAD-д хүсэлт гаргатал төсөл маань батлагдан 10 сая төгрөгийн төсөвтэй болсон ба, энэ мөнгөөрөө 2 га газар худалдан авсан. Үргэлжлүүлэн яаманд хандан агропарк дотроо худаг гаргах төсөв хүстэл тэр бас шийдэгдсэн. 2007 оны 7 сараас төсөл эхлэн, агропарк барих, малчид тариаланчдад зөвлөгөө өгөх, сургалт хэрэгжүүн, газар тариалангийн төхөөрөмжийн үзэсгэлэнг зохион байгуулсан. Эдгээр үйл ажиллагааг өөрийн болон хамт ажиллагчийн багшлах ур чадварыг дээшлүүлэхэд мөн холбогдох ирсэн. Малчид, газар тариаланчдын хувьд амьжиргаагаа дээшлүүлэхэд хувьд нэмэр болохоор мэдлэг, технологийг эзэмшиж болсон. Булган аймагт энэ төрлийн анхны арга хэмжээ ба тус аймгийн ХАА-н нэвтрүүлэх системийг бэхжүүлэх, сайжруулахад хувь нэмэрээ оруулсан гэж хэлж болно.


### Шууд бүс үр нөлөө

Төгсөгчдийн холбооны гишүүн боловч орон нутагт амьдардаг тул идэвхтэй үйл ажиллагаанд оролцж чаддаггүй боловч холбооны хэрэгжүүлж буй мод тарих үйл ажиллагааг дэмжих зорилготойгоор өөрийн ажлын байр болон Агропарк дээр мод тарих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

### Сургалтын үр нөлөө гарсан шалтгаан

Сургалтын агуулгын тухайд: Сургалтын агуулга болон буцаж ирсний дараах ажлын агуулга нийцэж байсан тул буцаж ирээд сургалтаар олж авсан санаагаа мэдээж ажил хэрэг болгож чадсан. Мөн сургалтын хөтөлбөрт лекц, практик, танилцах аялал зэрэг тэнцвэртэйгээр оруулсан байсан ба сургалтанд оролцогчийн сонирхолыг маш их татахаар хөтөлбөр байсан. Тиймээс сургалтын агуулгыг маш сайн ойлгож авч чадсан.





## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар  
 Төв шуудан 682, Улаанбаатар 211213, МОНГОЛ  
 ТЕЛ: +976-11325+39, +976-11-311329 FAX: +976-11-310845  
 URL: <http://www.jica.go.ip/mongolia>